

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: 2020 оны 01 дүгээр сарын 31

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН
ТӨВИЙГ ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАХ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар: ХУД2020/ДТХ-04-18

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 01 дүгээр сарын 31

Тендер шалгаруулалтын нэр: Хан-Уул дүүргийн албан бус насан туршийн боловсролын төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах

Тендер шалгаруулалтын дугаар: ХУД2020/ДТХ-04-18

Энэхүү ажил нь "Цахим тендер шалгаруулалтаар зохион байгуулах журам"-ын (www.tender.gov.mn) дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон Туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн борлуулалтын дундаж 40 000 000 /дөчин сая/ төгрөгөөс багагүй байх.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 1 жил /2019 он/**

Сүүлийн нэг жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **: Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн дундаж нь 30 000 000 /гучин сая/ төгрөгтэй тэнцэх өртөгтэй компьютер, тоног төхөөрөмж нийлүүлсэн байх, түүнийг нотлох баримт: Ажил гүйцэтгэсэн гэрээ, хүлээлцсэн актыг фото зургийн хамт ирүүлэх**

Шаардлагатай тусгай зөвшөөрөл: **байхгүй**

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй.**

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцохгүй.**

Үнийн саналыг **2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 10.00 минут**–аас өмнө өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 10.30 минут** -т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Цахим худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээс үнэ төлбөргүй татаж авна уу.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, Иргэдэд үйлчлэх төв байр, 9 давхарт 902 тоот, утас: 70009011

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 1.
 - 2.Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (1) Үнийн санал /маягтын дагуу албан бланк дээр бэлтгэсэн байх/ ;
 - (2) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; /гарын үсэг зурж баталгаажуулах/
 - (3) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (4) Шаардлагатай тусгай зөвшөөрөл /нотариатаар баталгаажуулсан байх/;
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага

үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт																				
ТООЗ -1.1 (а)	Захиалагч нь: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар																				
ТООЗ -1.1 (б)	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: Хан-Уул дүүргийн албан бус насан туршийн боловсролын төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Тендер шалгаруулалтын дугаар: ХУД2020/ДТХ-04-18																				
ТООЗ -1.1 (в)	Тендерт оролцогч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ. /албан бланк дээр баталгаажуулж ирүүлнэ/																				
ТООЗ -1.1 (г)	Тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийн баталгааг бичгээр гаргах, түүний итгэмжлэл /маягтын дагуу албан бланк дээр баталгаажуулж ирүүлнэ/.																				
ТООЗ -1.1 (д)	Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар. Үйл ажиллагааны чиглэл: Гадаад худалдаа /мөн түншлэлийн гишүүнд хамаарна /																				
ТООЗ -1.1 (е)	Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх: - Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт: /сүүлийн 3 жил хариуцагчаар орж байгаагүй байх./ - Цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолт; -Харьяа Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт -Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолт. -Нийлүүлэгдэх барааны нэр, үзүүлэлт, зураг зэргийг хавсарган танилцуулга бэлтгэж ирүүлэх																				
ТООЗ -3.1.2 (а)	1.Үнийн болон бараа нийлүүлэлтийн хуваарь /гарын үсэг зурж баталгаажуулах/ 2.Тендерт оролцогч нь санал болгосон үнийн дүнд багтаан тухайн ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.																				
ТООЗ -3.1.3 (а)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: /1/ 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан. Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: “шаардлагагүй”.																				
ТООЗ -3.1.3 (б)	Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх, шаардлагатай жилийн тоо: Сүүлийн 2 жил / 2018, 2019 он/																				
<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th> <th>Төсөвт өртөг</th> <th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Дүн</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>		№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа	1					2						Дүн			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа																	
1																					
2																					
	Дүн																				

ТООЗ -3.1.3 (б)	Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2018 он, 2019 он/-ийн дундаж борлуулалт 40 000 000 /дөчин сая/ төгрөгөөс багагүй байх.																				
ТООЗ -3.1.3 (в)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн дундаж нь 30 000 000 /гучин сая/ төгрөгтэй тэнцэх өртөгтэй компьютер, тоног төхөөрөмж нийлүүлсэн байх, түүнийг нотлох баримт: Ажил гүйцэтгэсэн гэрээ, хүлээлцсэн актыг фото зургийн хамт ирүүлэх <table border="1" data-bbox="507 416 1430 613"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th> <th>Төсөвт өртөг</th> <th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Дүн</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа	1					2						Дүн			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа																	
1																					
2																					
	Дүн																				
ТООЗ -3.1.3 (г)	Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон инженер, техник, мэргэжлийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Гэрээг хэрэгжүүлэх ажилтан нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байна, нийгмийн даатгалын дэвтрийн даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, нийгмийн даатгал төлсөн хэсгийн хуулбарыг ирүүлнэ, иргэний үнэмлэхний хуулбар																				
ТООЗ -3.1.4	Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагагүй.																				
ТООЗ - 5.1	Нийлүүлэгч нийлүүлсэн тоног төхөөрөмждөө 1 жил хугацаанд баталгаат хугацаа өгөх ба баталгаат засварын хугацаанд үйлдвэрийн гэмтлийг хариуцаж ажиллах тухай бичгийг албажуулж ирүүлнэ.																				
ТООЗ -2.1 (а)	Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд: Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.																				
ТООЗ 2.1 (б)	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 02 дугаар сарын 07–ны өдөр Цаг: 10 цаг 00 минут Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.																				
ТООЗ 2.2	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 3 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байр, Худалдан авах ажиллагааны алба Давхар болон өрөөний дугаар: 9 давхар 902 тоот өрөө Огноо: 2020 оны 02 дугаар сарын 07–ны өдөр Цаг: 10 цаг 30 минут																				
ТООЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [багцгүй]																				

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАТЛАВ
 ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 Б.ОИХБОЛД
 2020 оны 01 сарын 13-ны өдөр

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙГ
 ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН
 ТОДОРХОЙЛОЛТ

2020 оны 01 дүгээр сарын 13

Улаанбаатар хот


Д/д	Барааны нэр, төрөл	Тоо /ширхэг/	Техникийн үзүүлэлт
1.	Суурил компьютер	14	<ul style="list-style-type: none"> Процессор / CPU: 8-р үеийн Intel® Core i5 6700 2.7GHz Шуурхай санах ой / RAM: 1TB Хатуу диск / HDD: 1TB 7200 rpm SATA 6Gb/s Hard Drive Оптик драйв: DVD±RW (±R DL) / DVD-RAM - SATA Оролт гаралтууд: 4 x USB 2.0 2 x USB 3.0 Audio line-out Audio line-in 1 x LAN (Gigabit Ethernet) 1 x VGA 1 x DVI 220 Watt Power Supply •Дэлгэц:21,5" LED Display Нягтрал: 1920 x 1080 at 60 Hz Контраст: 1000:1 (typical) Response Time: 5 ms Оролт: VGA Харагдах өнцөг (босоо/хэвтээ): 160/170 градус Хэмжээ (суурьтай): 396.7 mm x 512.2 mm x 180.0 mm •Дагалдах хэрэгсэл: Keyboard Mouse Speaker Мини камер •Өнгө: Хар вирусны программ, office 365 2017 оны, photoshop cc17 програмтай
2.	Зөврийн компьютер	1	<ul style="list-style-type: none"> Процессор / CPU: 8th Gen Intel Core i5 8250U Шуурхай санах ой / RAM: 8GB DDR4 Хатуу диск / HDD: 1TB SSD Оролт / Ports & CD drive: 1USB 2.0, 1USB 3.0, 1HDMI, 1SD card reader /with CD drive/ Дэлгэц: 15.6" LED HD /1366x768/ Дэлгэцний карт: Ati radeon r5 520 2gb Ethernet: 10/100/1000 MX150 видео карттай Дагалдах: вирусны програм, office 365-2017,Optik mouse


			Зөөврийн компьютерийн зориулалтын цүнх
3.	Компьютерийн ширээ	14	1 хүнд зориулсан цайвар өнгийн
4.	Компьютерийн сандал	14	Зориулалтын дугуйтай оффис сандал
5.	Бойлуур	1	80 литрийн багтаамжтай халуун хүйтэн ус гардаг
6.	Үсчний сандал	4	Хүүхдийн өндөрлөгчтэй, төмөр суурьтай, савхин бүрээстэй
7.	Үсчний гэрэл	2	Үсчний халаагч гэрэл
8.	Тоос сорогч	1	1800 Ваттын хүчин чадалтай, цаасан ууттай 3,5 литрийн багтаамжтай
9.	Ариутгалын аппарат	2	Хананд тогтоох боломжтой
10.	Үсчний угаалтуур	1	Цагаан палантай, хар савхин суудалтай
11.	Үсчний туслах тавиур	10	Хар өнгийн төмөр суурьтай
12.	Сурагч сандал	10	Төмөр суурьтай хар савхин сандал
13.	Сурагч ширээ	5	Хэмжээ: 1200х600х750 мм Тавцан: Модны үртсэн шахмал Хөл: Төмөр
14.	Самбар	1	Цагаан өнгөтэй, хананд өлгөж тогтоохоос гадна самбарын хөл нэмэлтээр худалдан авч зөөвөрлөн хэрэглэх боломжтой.
15.	Хувцасны шкаф	1	3 хаалгатай хар саарал өнгөтэй хувцасны шүүгээтэй номын тавиуртай шилэн хаалгатай
	Нийт	81	


- ✓ Техник, тоног төхөөрөмжийг ашиглах ном, гарын авлагаар хангах.
- ✓ Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжүүдийн найдвартай хэвийн ажиллагааг шалгасны дараа хүлээлгэн өгөх.
- ✓ Нийлүүлсэн тавилга, хэрэгслийг тусгай шаардлагын дагуу угсарч суурилуулан хүлээлгэн өгөх.


Баталгаа:


- ✓ Барааны 1 жилийн баталгааны хуудастай байх.
- ✓ Баталгааг хугацаанд эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг хийх.

ХЯНАСАН :ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГИН ГАЗРЫН
ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ОТГОНБАЯР

ХЯНАСАН :ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГИН ГАЗРЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Н.МЭНДБАЯР

ХЯНАСАН :АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН
ТӨВИЙН ЗАХИРАЛ  Т.РЭГЗЭДМАА

БОЛОВСРУУЛСАН :ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДЭД БҮТЦИЙН
ХӨГЖИЛ,ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  О.МӨНГӨНШАГАЙ

БОЛОВСРУУЛСАН : НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Б.САРАНЦАЦРАЛ

1. **Стандарт:** Нийлүүлэгдэх бараа нь Монгол улсад мөрдөгдөж байгаа болон олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан, гарал үүсэл, үйлдвэрлэгч нь тодорхойлолтыг тендерийн баримт бичигт загварыг хавсаргаж ирүүлнэ.

2. **Баглаа, боодол:** Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад эвдрэх гэмтэхээс урьдчилан сэргийлэх баглаа боодлоор хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна.
3. **Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Хан-Уул Албан бус насан туршийн боловсролын төв
4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Тоног төхөөрөмжийн нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэм жиж нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
	2	3	4	5	6	7	8
1	Суурин компьютер	14	и	Хан-Уул Албан бус насан туршийн боловсролын төв	<i>Гэрээ хийснээр хойш 10 хоногийн дотор</i>	21 хоног	
2	Зөөврийн компьютер	1					
3	Компьютерийн ширээ	14					
4	Компьютерийн сандал	14					
5	Бойлуур	1					
6	Үсчний сандал	4					
7	Үсчний гэрэл	2					
8	Тоос сорогч	1					
9	Ариутгалын аппарат	2					
10	Үсчний угаалтуур	1					
11	Үсчний туслах тавиур	10					
12	Сурагч сандал	10					
13	Сурагч ширээ	5					
14	Самбар	1					
15	Хувцасны шкаб	1					

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

1. ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч _____
Компанийн _____ ажилтай _____ овогтой _____ нь _____ компанийн
нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн тул
_____ овогтой _____ ын дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

_____ овогтой _____ нь _____ компанийг төлөөлж _____
компанийн нэр дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах,
гологдлыг барагдуулах, албан бичиг баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад
холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 20__оны __ дугаар сарын __ ны өдөр гарын үсэг
зурав.

Тэмдэг

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн
Овог, нэр _____
Гарын үсэг _____

Баталгаажуулагчийн
Овог, нэр _____
Гарын үсэг _____

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ажлын 7 хоног] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1. Барааг комисс шалгаж хүлээн авах ба шаардлагатай бол үйл ажиллагааны туршилтуудыг хийнэ. Нийлүүлэгч нь захиалагчид шалгуулж хүлээлгэн өгнө.

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
 - 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) Барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

Нийлүүлэгч нийлүүлсэн тоног төхөөрөмждөө **1 жил** хугацаанд баталгаат хугацаа өгөх ба баталгаат засварын хугацаанд үйлдвэрийн гэмтлийг хариуцна. Тоног төхөөрөмжийн ажиллах зааврын талаар захиалагчид [*Монгол хэл*] дээр орчуулсан гарын авлага гаргаж өгнө.

4. Төлбөр (ГЕН – 7)
 - 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
 - 9.1. Алданги оногдуулах хувь: **0.05 хувь**

Алдангийн нийт дүн: **10 хувь**

6. Чанарын баталгаа
 - 6.1. Чанарын баталгаа нь гэрээний үнийн [**5 хувь**]-иас доошгүй дүнтэй байна.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]